

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР СУМЫН НУТАГТ ШИНЭЭР ОЛДСОН ГУРВАН ХЭРЭМ

З.БАТСАЙХАН, Ё.БААТАРБИЛЭГ
МУИС-ийн антропологи-археологийн тэнхим

МУИС-ийн Антропологи-Археологийн ангийн 2001 оны зуны археологийн хээрийн дадлагаар дурдсан хэрмүүдийг шинээр илрүүлэн олсон юм. Тус хэрэм нь Улаанбаатараас Батцэнгэл сум орох замын хойт талд, Өгийнуур сумын төвөөс хойш 20 км орчимд /Батцэнгэл сумаас зүүн тийш 32-33 км/, уужим, энгэр газарт байрладаг. Хойт талд нь нэлээд зайдуу /2-3 км орчим?/ намхавтар ухаа толгодтой, баруун хойт талд нь Хиргисүүрийн магнай уул, баруун урд талд нь Цант хэмээх ухаа орших бөгөөд энд дугуй болон дөрвөлжин хиргисүүр цөөвтөр тохиолдоно. Хэрмийн урд талаар Тамирын гол /2-км-т/ урсах ба ялимгүй зүүн урд талд /5-км-т/ Бурхантолгой, чанх баруун талд нь Эмээл толгой хэмээх хүннү булш бүхий оршуулгын газрууд байна.

Хэрмэн талын балгас нь баруунаас зүүн тийш цуварсан гурван хэрмээс тогтоно.

Баруун талын хэрэм нь 1.5 м өндөр, 400 х 452м хэмжээтэй. Хойт ба баруун, зүүн урд талдаа хаалгатай. Хаалганы өргөн 10 м. Хэрмийн дотор, төв хэсэгт 35х25м хэмжээтэй ордны туурь /довжоо/ байх ба түүний баруун урд ба урдхан талд 4 хэсэг шороон довжоонууд байна.

Дунд хэрэм нь, баруун хэрмээс 150 м зайд орших ба 430 х 290 м хэмжээтэй, баруун болон урд талдаа хаалгатай байсан бололтой. Хаалганы өргөн 10м. Хэрмийн дотор байрлах довжоо нь баруун хэрмийнхээс өндөр, 25х35 м хэмжээтэй. Түүнээс урдхан талд 1, баруун урд 3 хэсэг жижиг шороон овгорууд, зүүн хананы орчим бас 1 овгор байна.


Зүүн хэрэм нь намхан, газарт үл мэдэгдэх шахуу болсон бөгөөд дунд хэрмээс 270 м зайд оршино. Хэрэм нь зөвхөн баруун талдаа хаалгатай байсан бололтой ба хэрмийн дотор, төв хэсэгт байрлах 25 х 20 м хэмжээтэй шороон довжооны баруун урдхан хэсэгт 3 хэсэг шороон овгорууд байна.

Эдгээр хэрмүүд нь урд өмнө нь судалгааны хүрээнд огт ороогүй бөгөөд энэ удаагийн хайгуул судалгаагаар хэмжээ болон бүтэц зохион байгуулалтыг мэдэх зорилгоор гүймэг судалсан болно. Хэрмүүдээс он цагийг урьдчилан тогтоох ямар нэг хэрэглэгдэхүүн олдоогүй боловч зүүн баруун талд нь орших Тамирын Улаан хошуу, Эмээл толгой зэрэг газрын хүннү булшуудтай түүхэн холбоотой байж болох юм.




Дээрх гурван хэрмээс зүүн урдхан байрлах /5 км-т/ Тамирын Улаан хошуу хүннү булшны оршуулгын газар нь 280 орчим булштай, нилээд томоохон дурсгал болно. Сүүлийн 3 жилд зохион явуулсан хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс үзэхэд дээрх газруудаас европжуу болон монгол төрхтөний холимог шинжийг агуулсан палеоантропологийн хэрэглэгдэхүүн олдож байна.

Үүнээс гадна Хэрмэн талын балгаснаас баруун хойт зүгт Батцэнгэл орох зам дээр 7-10 км-т. Ар хүрэн шанд хэмээх газарт нэгэн хэрмийг шинээр илрүүлэн олсон боловч түүний талаар ямар нэгэн тэмдэглэл хийгээгүй.

Цаашид дээрх хэрмүүдийг бүх талаас нь нарийвчлан судлах шаардлагатай байна.



1-зураг 10-р булш, 3-р зураг, 13-р булш. 4-р зураг, 6-р булш. Архангай аймаг, Өгийнуур сум, Тамирын улаан хошуу, 2-р зураг 10-р булш. Архангай аймаг, Батцэнгэл сум, Эмээл толгой. 5-11-р зураг, 10-р булш. Архангай аймаг, Өгийнуур сум. Тамирын улаан хошуу. 12-р зураг, 6-р булш. 13-р зураг, 9-р булш. Архангай аймаг, Батцэнгэл сум, Эмээл толгой.



Архангай аймаг, Өгий нуур сум, Хэрэм талын зэрэгцээ гурван хэрмийн тойм зураг